



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/13

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын Агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоол, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Зөвшөөрлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дгээр зүйлийн 19.11, 19.12 Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/400 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хүний эм, эмнэлгийн хэрэгсэл болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, тэдгээрийн угтвар бодис, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын тусгай зөвшөөрлийн орон тооны бус шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.


2.Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЗЭНДМАА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.13 оны 01 дугаар сарын 16 -ны
өдрийн 1/15 дугаар тушаалын хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ОРОН ТООНЫ БУС ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Т.Мөнхтуул (Эмийн бүртгэлийн хэлтсийн дарга)

Гишүүд:

О.Одончимэг (Шинэ эм, эмнэлзүйн судалгааны
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Л.Батзориг (Хуулийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Г.Номин (Эм, биобэлдмэлийн улсын ахлах байцаагч)

М.Долгион (Эмийн бүртгэлийн зохицуулалтын
асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Д.Бямбаа (Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн
үйлдвэрлэх, ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийн
асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Амарсанаа (Эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног
төхөөрөмж, протез үйлдвэрлэх, ханган нийлүүлэх
тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)